



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 146

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээ”-ний тухай Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Иргэдээс төрийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлсэн 4 нэрийн нийт 190,210,246.00 (нэг зуун ерэн сая хоёр зуун арван мянга хоёр зуун дөчин зургаан) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг хүлээн авч, “Дарханы дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Дарханы дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Гантуул нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн ашигласан хугацаанд ногдох элэгдэл хорогдлын шимтгэлийг тооцон зохих хууль тогтоомж, журмын дагуу бодит үнэ цэнээр нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13201740

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
146 дугаар тогтоолын хавсралт

**"ДАРХАНЫ ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр, байршил	Хүчин чадал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)
1	Дархан сумын 6 дугаар багийн 60 айлын орон сууцны гадна дулааны шугам	Ф89 мм	хос метр	60	51,075,339.00
2	Дархан сумын 6 дугаар багийн 60 айлын орон сууцны ялтсан халаагч бүхий дулааны узель	Ф700квт	Ком	1	81,434,907.00
3	Дархан сум 10-р баг 5-10 байрны гадна дулааны шугам	Ф76 мм	хос метр	93	30,000,000.00
4	Дархан сум 10-р баг 5-10 байрны ялтсан халаагч бүхий дулааны узел	-	Ком	1	27,700,000.00
Нийт дүн					190,210,246.00 (нэг зуун ерэн сая хоёр зуун арван мянга хоёр зуун дөчин зургаан)